





НОМ СУРАХ БИЧИГ:


	<p>“Агаар сэлгэлт”, Ц.Дашдорж, Д. Пүрэвсүрэн 2010 он</p> <p>Агаар сэлгэлт төсөл тооцооны энэхүү гарын авлага нь барилга, өрөө, тасалгаа, цех тасгийн агаар сэлгэлтийн системийн зохион төсөллөх, тэнд ялгарах хортой зүйлийн төрөл, хэмжээнээс хамааруулан солилцуулах агаарын тоо хэмжээг тодорхойлж тухайн барилгын онцлог, технологийн үйл ажиллагаатай уялдуулан агаар сэлгэлтийн системийг сонгон төсөллөж түүнийг онолын тооцоо хийж улмаар шаардлагатай тоног төхөөрөмжийг сонгох зэргээр системийн зураг төсөл зохиох онол, практикийн мэдлэг чадвар эзэмшүүлэх зорилготой бүтээл юм.</p>
	<p>“Халаалт, агаар сэлгэлтийн системийн угсралт” Ц.Дашдорж, Ц.Уранцэцэг, 2011 он</p> <p>Сурах бичигт дулаан хангамж, дулааны эх үүсгүүр, дулааны шугам сүлжээ, дотор халаалт агаар сэлгэлт хэсгүүдээс, бүрдэх бөгөөд эдгээрийн тус бүрийн тухай ойлголтууд, тоног төхөөрөмж, угсралтыг оруулсан.</p>
	<p>“Халаалт, агаар сэлгэлтийн системийн угсралт” Ц.Дашдорж, Ц.Уранцэцэг, 2011 он /Нэмэлт оруулсан сайжруулсан хоёр дах хэвлэл/</p> <p>Сурах бичгийг мэргэжилтэй ажилчин бэлтгэх бүх шатны суралцагчдад зориулсан бөгөөд сурах бичигт халаалт агаар сэлгэлтийн болон сантехникийн системүүдийн сүүлийн үеийн угсралтын технологи, тоног төхөөрөмжийн угсралт, ашиглалт шинэчлэлийн талаар илүү оруулсан бүтээл юм.</p>
	<p>“Халаалт, агаар сэлгэлт” Ц.Дашдорж, Н.Ангараг, 2012 он</p> <p>Энэ гарын авлагыг архитектур ба барилга, халаалт агаар сэлгэлт, сантехникийн инженер мэргэжлээр бэлтгэгдэж байгаа оюутнуудад төсөл тооцоо хийх, зураг төсөл боловсруулах, барилгын дулаан техник, халаалт, агаар сэлгэлтийн системийн тооцоонд ашиглахад зориулан төсөл тооцооны аргачлал болгон холбогдох лавлах, норм дүрмийг хураангуйлан оруулсан.</p>

<p>Ц.ЦАЦРАЛ</p> <p>БОХИР УС ЦЭВЭРЛЭГЭЭ</p>  <p>Уламбартуулалт 2013 он</p>	<p>“Бохир ус цэвэрлэгээ” Ц. Цацрал, 2013 он</p> <p>Энэхүү сурах бичигт ахуйн ба түүнтэй ойролцоо найрлагатай үйлдвэрийн бохир усыг механик, биологи болон бусад аргуудаар цэвэрлэх зориулалттай байгууламж, тоног төхөөрөмжүүдийг төсөллөх, тооцох аргачлал, тооцооны жишээг үзүүлсэн.</p>
 <p>МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ БАРИЛГЫН ИНЖЕНЕР АРХИТЕКТУРЫН СУРГУУЛЬ</p> <p>Ц.ДАШДОРЖ Д.ПҮРЭВСҮРЭН</p> <p>АГААР СЭЛГЭЛТ (ТӨСӨЛ ТООЦООНЫ ГАРЫН АВЛАГА)</p> <p>Уламбартуулалт 2014 он</p>	<p>“Агаар сэлгэлт” төсөл тооцооны гарын авлага Ц.Дашдорж, Д.Пүрэвсүрэн, 2014 он</p> <p>Сантехникийн инженер мэргэжлийн халаалт, агаар сэлгэлтийн ахлах ангийн болон барилга, хөнгөн, хүнсний мэргэжлийн оюутнууд орон сууц, олон нийтийн барилгын агаар сэлгэлтийн системийн иж бүрэн тооцоо, зураг төслийг гүйцэтгэхэд хэрэглэхээс гадна зураг төслийн инженер техникийн ажилтнууд тооцоо төсөлдөө ашиглах бүрэн боломжтой гарын авлага болгохыг зорьсон бөгөөд холбогдох лавлах материалуудыг хураангуйлан хавсаргасан болно.</p>
 <p>ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ</p> <p>ИНЖЕНЕРИЙН ЛАВЛАХ БОТЬ I</p> <p>ХҮРЭЭЭН БҮЙ ОРЧНЫ ИНЖЕНЕРИЙН САЛБАР</p> <ul style="list-style-type: none"> • Дулаан хамгаалалт • Халдлага • Агаар сэлгэлт • Кондиционер • Дулаан хангамж • Хий хангамж <p>11</p> <p>2014 он</p>	<p>“Инженерийн лавлах Боть-I” Ц.Дашдорж, Б.Болормаа, Б.Мөнхбаяр, Д.Эрдэнэцэцэг, Ч.Наранцацрал, Ц.Уранцэцэг, Х.Баатарсүрэн, Б.Билгүүн, 2014 он</p> <p>Энэхүү боть нь барилгын дулаан физик, халаалт, агаар сэлгэлт, кондиционер, дулаан болон хий хангамжийн сэдвүүдийг багтаасан. Лавлах онолын үндэслэлтэйгээр, орчин үеийн техникийн шийдэл, тооцооны аргачлал, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй үндэсний норматив бичиг баримтуудад тулгуулан хийгдсэн.</p>




“Инженерийн лавлах Боть-II”, С.Чулуунхуяг, Ц.Цацрал, Ж.Даваацэрэн, П.Болд, Ц.Дашдорж, С.Алтансүх, С.Эрхэмбаяр, Б.Наранцэцэг, Б.Лхагвадулам, Х.Баатарсүрэн, 2014 он

Усны технологийн салбар, түүнтэй хамааралтай чиглэлүүдийг багтаамж, ус хангамжийн эх үүсвэр, олборлолт ба байгууламж, гидравлик, шингэн ба хийн кинематик, тэдгээрийн тооцоо, ус хангамж, бохир усны систем, бие даасан ариун цэврийн байгууламж, барилгын сантехникийн тоног төхөөрөмж, үйлдвэрийн ус хангамж, ариутгах татуурга, усны хими, микробиологи зэрэг хэрэглээнд ойрхон инженерийн зайлшгүй мэдэх ухагдахуун, өгөгдөлүүдийг зураг, схем, хүснэгт тооцооны гаргалгаа хэлбэрээр оруулсан болно.






**“Ногоон барилга”
Д.Сүнжидмаа, Б.Лхагвадулам, Б.Мөнхбаяр, Ц.Цацрал, С.Амгалан, С.Энхболд, 2015 он**

Монгол Улсын Засгийн Газрын стратегид барилгын салбарыг ногоон болгох тал дээр анхаарч байгаатай холбогдуулан энэхүү сургалтын материал нь Хүрээлэн буй орчинд суурилсан чиглэл, Барилгын үйл ажиллагааны бусад талууд, Европын практикт үндэслэн монголын нөхцөлд тааруудсан, онолын суурийг практикт жишээгээр тайлбарласан зэрэг дараах сэдвүүдийг онцолсон.



**“Халаалт, агаар сэлгэлт”
Ц.Дашдорж, Д.Пүрэвсүрэн, 2016 он**

Дулаан хамгаалалтын ба халаалт агаар сэлгэлтийн систем тооцоонд орчин үед хэрэглэгдэж байгаа тооцооны аргачлал, шинэ технологи нэвтрэлт, өргөн хэрэглэж байгаа тооцооны аргачлал, шинэ технологи нэвтрэл, өргөн хэрэглэж байгаа шинэ тоног төхөөрөмж, хэрэгслийг оруулж манай оронд мөрдөгдөж байгаа, норм, дүрэм, ном сурах, хамтын бүтээлийг ашиглан сайжруулсан дөрөв дэх хэвлэл юм.

	<p align="center">“Монгол хонины ноосон дулаан тусгаарлагч материал” Ц.Уранцэцэг, 2016 он</p> <p>Хонины ноосон дулаан тусгаарлагч материалыг Монгол орны цаг уурын янз бүрийн бүс нутагт баригдах барилгын хашлага бүтээцэд тохируулан хэрэглэх нь үр дүнтэй бөгөөд дулаан хамгаалалтын тооцоог оновчтой болгох шаардлагат практикт шийдвэрлэх асуудлын нэг болохыг харуулсан болно.</p>
	<p align="center">“Барилгын ус хангамж, ариутгах татуурга” Ц.Дашдорж, Ц.Цацрал, Ж.Даваацэрэн, 2016 он</p> <p>Барилгын ус хангамж, ариутгах татуургын системийн төсөллөлтийн талаар судлаж буй оюутан болон системийн тооцоо, зураг төсөл зохиох, инженер, техникийн ажилтан ашиглахад зориулан аргачилсан гарын авлага болгон холбогдох лавлах, норм дүрмийг хураангуйлан хавсарган боловсрууллаа.</p>
	<p align="center">“Халаалт” Ц.Дашдорж, 2018 он</p> <p>Халаалтын системийн төсөл тооцооны энэ гарын авлагыг Халаалт агаар сэлгэлтийн, Сантехникийн инженерийн байгууламжийн болон барилгын инженерийн мэргэжил эзэмшиж байгаа оюутнууд системийг төсөллөх, тооцох мөн зураг төслийн инженер техникийн ажилтнууд барилгын дулаан техник, халаалтын системийн тооцоонд ашиглахад зориулан аргачилсан гарын авлага юм.</p>
	<p align="center">“Ногоон барилгын төлөвлөлт” Б.Мөнхбаяр, С.Амгалан, П.Мандахнаран, Ц.Оюунцацрал, С.Энхболд, Ц.Цацрал, Ч.Наранцацрал, Б.Мөнхбаяр, Д.Сүнжидмаа, Б.Лхагвадулам, Б.Мөнхбаяр, 2019 он</p> <p>Энэ номыг барилгын зураг төслийн байгууллага, барилга угсралтын компани, барилгын салбарын их, дээд сургууль, барилгын зураг төслийн байгууллагуудын сургалтын хэрэгцээнд зориулан боловсруулав. Номыг орон сууц, олон нийтийн зориулалттай барилга, нийтийн барилгыг төлөвлөхөд ашиглахад тохиромжтой.</p>



**“Барилгын хаягдал боловсруулах технологи”,
Б.Лхагвасүрэн, Д.Мөнхцэцэг,, Д.Сүнжидмаа, Б.Нарантуяаг,
Р.Болормаа, Ц.Оюунцацрал, 2020 он**

Хүрээлэн буй орчны инженерийн салбарын “Хаягдал боловсруулах технологи” мэргэжлийн оюутнуудад зориулав.